Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС





# ХӨДӨӨ АЖ АХУЙН ТООЛЛОГЫН ДҮНД ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

# 2013









Баруун-Урт хот
2014 он

# АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ
ЗУРГИЙН ЖАГСААЛТ
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ
ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ТООЦОХОД АШИГЛАХ ИТГЭЛЦҮҮР
ОРШИЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ ....10-12

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ, АХУЙН НӨХЦӨЛ ....13

2.1. Мал бүхий өрх, малчид....14-15
2.2. Малчдын соёл, ахуйн үзүүлэлтүүд ....15-16

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МАЛЫН ТОО, БҮТЭЦ....17

3.1. Малын тооны өсөлт, бууралт....18-20
3.2. Хувийн /амины/ малын тоо....20-22
3.3. Хээлтэгч мал....22-23
3.4. Төл бойжилт....23-24
3.5. Том малын зүй бус хорогдол....24-25
3.6. Малын хээл хаялт, сувайралт....26
3.7. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо....26
3.8. Малын хэрэглээний зарлага....27
3.9. Сүргийн бүтэц....27-28
3.10. Цэвэр үүлдрийн болон эрлийз мал....28

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МАЛЫН ТЭЖЭЭЛ ....29-30

ТАВДУГААР БҮЛЭГ. ТЭЖЭЭВЭР АМЬТАД....31

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ....32-33

ДОЛООДУГААР БҮЛЭГ. ШИНЭЭР ГАРГАСАН БОЛОН ЗАСВАРЛАСАН ХУДГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ....34-35

НАЙМДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ТАРИАЛАН....36

8.1. Тариалсан талбай....37
8.2. Хураасан ургац....38

ДҮГНЭЛТ....39-40
АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ....40
ХАВСРАЛТ....41
ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ....42-54

**ТАНИЛЦУУЛГА ХЯНАСАН: ХЭЛТСИЙН ДАРГА**

**Т.ЭРДЭНЭБАТ**

**ТАНИЛЦУУЛГЫГ БОЛОВСРУУЛСАН: МЭРГЭЖИЛТЭН**

**Э.АНХЦЭЦЭГ**

САНАЛ ХУСЭЛТ БАЙВАЛ ДООРХ

ХАЯГААР ХОЛБОО БАРИНА УУ.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Монгол улс, Сүхбаатар аймаг
Баруун-Урт сум, 7-р баг
Аймгийн нутгийн удирдлагын ордон
Өрөө: 103 тоот
Утас: 70518203, 98711185
И-мэйл: sukhbaatar@nso.mn
Интернет хаяг: web.nso.mn/portal/sukhbaatar
www.facebook.com/statistic

Баруун-Урт сум
2013 он

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1.1. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт...11
Хүснэгт 1.2. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт...12
Хүснэгт 2.1. Өрх, малчдын тоо, насны бүтэц...13
Хүснэгт 2.2.1. Малчин өрхийн нийгэм ахуйн үзүүлэлтүүд...14
Хүснэгт 2.2.2. Цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо...14
Хүснэгт 3.1.1. Малын тоо, төрлөөр...15
Хүснэгт 3.1.2. Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь...15
Хүснэгт 3.2.1. Хувийн малын тоо...17
Хүснэгт 3.2.2. Малтай өрхийн малын бүлэглэлт...17
Хүснэгт 3.2.3. Малтай нэг өрхөд ноогдох малын тоо, бүлэглэлтээр...18
Хүснэгт 3.3. Хээлтэгч малын тоо...18
Хүснэгт 3.4.1. Төл бойжилт...19
Хүснэгт 3.4.2. 100 эхээс бойжуулсан төл...20
Хүснэгт 3.5.1. Том малын зүй бус хорогдол...21
Хүснэгт 3.5.2. Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо...21
Хүснэгт 3.6. Хээл хаяж, сувайрсан малын тоо...22
Хүснэгт 3.7.1. Хээлтүүлэгч малын тоо...22
Хүснэгт 3.7.2. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо...22
Хүснэгт 3.8.1. Малын хэрэглээний зарлага...23
Хүснэгт 3.8.2. Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн малын тоо...23
Хүснэгт 3.9. Сүргийн бүтэц...24
Хүснэгт 3.10. Цэвэр үүлдрийн болон эрлийз мал...24
Хүснэгт 6.1. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийн тоо, ам бүлээр...25
Хүснэгт 6.2. Малжуулах арга хэмжээгээр олгогдсон малын тоо...26
Хүснэгт 6.3. Малжуулах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн тайлан...26
Хүснэгт 7.1.1. Шинээр гаргасан худгийн тоо...26
Хүснэгт 7.1.2. Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгө...27
Хүснэгт 7.2.1. Засварласан худгийн тоо...27
Хүснэгт 7.2.2. Худаг засварлахад зарцуулсан хөрөнгө...27
Хүснэгт 8.1. Тариалсан талбай, га-гаар...29
Хүснэгт 8.2. Хураасан ургац, тн-оор ...30

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. ДНБ-д ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь................................11
Зураг 2.1. Малчдын тоо, мян.хүн.........................................................................................12
Зураг 2.2. Малчин өрхийн нийгэм, ахуйн үзүүлэлтүүд, мян.өрх.................................14
Зураг 3.1.1. Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь............................................16
Зураг 3.1.2. Малын тоо, сумаар, мян.тол........................................................................16
Зураг 3.1.3. Малын тоо, аймгаар, мян.тол......................................................................16
Зураг 3.3. Хээлтэгч малын тоо, мян.тол.........................................................................19
Зураг 3.4.1. Бойжуулсан төлийн тоо, мян.тол................................................................19
Зураг 3.4.2. 100 эхээс бойжуулсан төл...........................................................................20
Зураг 3.5. Том малын зүй бус хорогдол, мян.тол.........................................................21
Зураг 3.9. Сүргийн бүтэц, 2013 он....................................................................................24
Зураг 4.1. Бэлтгэсэн хадлан, тн.........................................................................................25
Зураг 8.1. Төмс, хүнсний ногооны тариалсан талбай, га............................................29
Зураг 8.2. Хураасан ургац, тн............................................................................................30

## ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх: Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай
Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай
Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай
Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

Тэмээ - Өмнөх оны төл, 2, 3 настай
Адуу - Өмнөх оны төл, 2 настай
Үхэр - Өмнөх оны төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл: Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна. Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
  1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
  2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
  3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай: Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай: Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай: Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац: Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

Нийт ургац: Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

Эдийн засгийн бүс:

Баруун бүс - Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан
Хангайн бүс - Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл
Төвийн бүс - Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул
Зүүн бүс - Хэнтий, Дорнод, Сүхбаатар
Улаанбаатар бүс - Улаанбаатар хот

## ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХОД АШИГЛАХ ИТГЭЛЦҮҮР

### Бодод шилжүүлэх коэффициент:

| | | |
|---|---|---|
| 1 адуу, үхэр | = | 1 бод |
| 1 тэмээ | = | 1.5 бод |
| 6 хонь | = | 1 бод |
| 8 ямаа | = | 1 бод |

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, хорогдол буюу бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

### Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

| | | |
|---|---|---|
| 1 тэмээ | = | 5 хонь |
| 1 адуу | = | 7 хонь |
| 1 үхэр | = | 6 хонь |
| 1 хонь | = | 1 хонь |
| 1 ямаа | = | 0.9 хонь |

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

### Нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

| | | |
|---|---|---|
| Буур | = | 20 |
| Азарга | = | 10 |
| Бух | = | 25 |
| Хуц, ухна | = | 50 |

### Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент:

| | | |
|---|---|---|
| Хадлан өвс | = | 0.45 |
| Таримал тэжээл | = | 0.35 |
| Даршны ургамал | = | 0.25 |
| Гар тэжээл, хужир шүү | = | 1.00 |
| Төмс ногооны хаягдал | = | 0.22 |
| Үр тарианы хаягдал | = | 0.90 |
| Лай | = | 0.40 |
| Сүрэл | = | 0.25 |

Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж, тэжээлийн хангамжийг гаргана.

### Тариалсан талбайг га-д шилжүүлэх итгэлцүүр

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 га | = | 10000м2 | = | 100м*100м |
| 1 сот | = | 100м2 | = | 10м*10м |
| 100 сот | = | 10000м2 | = | 1га |

### Хураасан ургацыг хэмжих нэгж

| | | |
|---|---|---|
| 1 кг | = | 1000 грамм |
| 1000 кг | = | 1 тн |
| 100 кг | = | 1 центнер |
| 1 тн | = | 10 центнер |
| 1000000 гр | = | 1 тн |

### Нэг га-гийн ургацын норм

| | | |
|---|---|---|
| Төмс | = | 120 центнер |
| Буудай | = | 11 центнер |

#### Хүнсний ногоо

| | | |
|---|---|---|
| Сонгино | = | 80 центнер |
| Лууван | = | 70-80 центнер |
| Манжин | = | 80 центнер |
| Байцаа | = | 230 центнер |

#### Жимс, жимсгэнэ

| | | |
|---|---|---|
| Чацаргана | = | бутнаас 3кг |
| Үхрийн нүд | = | бутнаас 800-1200 г |

## ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай байх бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагддаг.

Манай аймгийн эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

“Монгол улсын үндсэн хууль”-нд “мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нэгтгэн тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол улсын хуулийн 7-р зүйлийн 1 дэх заалт, Монгол улсын засгийн газрын 2003 оны 224-р тогтоол, аймгийн ИТХ-ын 67 тоот тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Үндэсний Статистикийн хорооноос мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулж явуулах албан бичгийн дагуу мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2013 оны 12-р сарын 7-оос 17-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж явуулсан.

2008 оноос манай аймагт малын индексжүүлсэн даатгалын төсөл хэрэгжиж 6 дахь жилдээ хагас, бүтэн жилээр малтай өрхийн картыг шивж тооллогын дүнг цахимаар тушааж хэвшээд байна.

Малын 2013 оны тооллогыг уламжлалт маягт, зааврын дагуу явуулж, өрх нэг бүрээр онлайнд шивж, үр дүнг нэгтгэн гаргаж аймгийн удирдлагуудад танилцуулан ҮСХ-нд хүргүүлсэн.

Энэхүү танилцуулгад малын 2013 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, голлох нэр төрлийн түүхий эд үйлдвэрлэлийн хэмжээ болон шинээр гаргасан, сэргээн засварласан худаг, уст цэг, малжуулалтын талаар тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

## ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2013 оны ДНБ (Дотоодын нийт бүтээгдэхүүн)-ий урьдчилсан гүйцэтгэлээр хөдөө аж ахуйн салбар 44.2 хувийг эзэлж байгаа нь 2011 оноос 5.5 пунктээр, 2008 оноос 12.4 пунктээр тус тус өссөн байна.

## ХҮСНЭГТ 1.1. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

| | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013* | 2013*/2012 | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хувь | Зөрүү |
| Бүгд | 111 730.3 | 133 101.9 | 158 330.1 | 202 269.6 | 258 231.3 | 127.7 | 55 961.7 |
| ХАА, ан агнуур, ойн аж ахуй | 33 966.0 | 48 049.8 | 62 065.4 | 78 278.3 | 114 138.2 | 145.8 | 35 859.9 |
| ДНБ-ий дүнд эзлэх хувь | 30.4 | 36.1 | 39.2 | 38.7 | 44.2 | 114.2 | 5.5 |

Тайлбар: *- урьдчилсан гүйцэтгэлээр

## ЗУРАГ 1.1. ДНБ-Д ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ




Тайлбар: *- урьдчилсан гүйцэтгэлээр

Хөдөө аж ахуйн салбар, түүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

## ХҮСНЭГТ 1.2. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

| | Биет хэмжээ | | Дундаж эзлэх хувь | | 2013/2012 | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2012 | 2013 | 2011 | 2013 | Хувь | Зөрүү |
| **Мах, тн** | **30 244.8** | **30 581.8** | **100.0** | **100.0** | **101.1** | **337.0** |
| Тэмээ | 928.3 | 787.6 | 3.1 | 2.6 | 84.8 | - 140.7 |
| Адуу | 4 707.1 | 5 042.2 | 15.6 | 16.5 | 107.1 | 335.1 |
| Үхэр | 7 298.2 | 7 197.0 | 24.1 | 23.5 | 98.6 | - 101.2 |
| Хонь | 10 323.5 | 10 102.8 | 34.1 | 33.0 | 97.9 | - 220.7 |
| Ямаа | 6 986.0 | 7 450.5 | 23.1 | 24.4 | 106.6 | 464.5 |
| **Сүү, тн** | **26 305.9** | **27 691.8** | **100.0** | **100.0** | **105.3** | **1 385.9** |
| Ингэний | 79.4 | 67.0 | 0.3 | 0.2 | 84.4 | - 12.4 |
| Гүүний | 2 406.2 | 2 476.4 | 9.1 | 8.9 | 102.9 | 70.2 |
| Үнээний | 16 463.8 | 17 097.6 | 62.6 | 61.7 | 103.8 | 633.8 |
| Хонины | 5 355.4 | 5 880.7 | 20.4 | 21.2 | 109.8 | 525.3 |
| Ямааны | 2 001.2 | 2 170.1 | 7.6 | 7.8 | 108.4 | 168.9 |
| **Ноос, ноолуур, мян.тн** | **1 374.6** | **1 501.6** | **100.0** | **100.0** | **109.2** | **127.0** |
| Тэмээний ноос | 36.7 | 33.6 | 2.7 | 2.2 | 91.5 | - 3.1 |
| Хонины ноос | 998.3 | 1 097.8 | 72.6 | 73.1 | 110.0 | 99.5 |
| Ямааны ноолуур | 299.2 | 325.4 | 21.8 | 21.7 | 108.7 | 26.2 |
| Бодын хөөвөр | 12.9 | 14.3 | 0.9 | 1.0 | 110.8 | 1.4 |
| Бодын хялгас | 25.3 | 28.2 | 1.8 | 1.9 | 111.4 | 2.9 |
| **Арьс, мян.ш** | **617.0** | **604.3** | **100.0** | **100.0** | **97.9** | **- 12.7** |
| Тэмээ | 2.6 | 2.2 | 0.4 | 0.4 | 84.2 | - 0.4 |
| Адуу | 20.5 | 21.7 | 3.3 | 3.6 | 105.6 | 1.2 |
| Үхэр | 33.0 | 30.9 | 5.4 | 5.1 | 93.6 | - 2.1 |
| Хонь | 313.4 | 302.6 | 50.8 | 50.1 | 96.6 | - 10.8 |
| Ямаа | 238.8 | 246.9 | 38.7 | 40.9 | 103.4 | 8.1 |

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг урьд онтой харьцуулахад мах 1.1 хувь, сүү 5.3 хувь, ноос, ноолуур 9.2 хувиар тус тус өсч, арьс, шир 2.1 хувиар буурч байна.

*Тайлбар: МАА-н нийт бүтээгдхүүнийг урьдчилсан байдлаар тооцлоо.*

# ХОЁРДУГААР БҮЛЭГ

## МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ, АХУЙН НӨХЦӨЛ

## 2.1. МАЛ БҮХИЙ ӨРХ, МАЛЧИД

Аймгийн хэмжээгээр 2013 оны мал тооллогын дүнгээр мал бүхий 9.2 мянган өрх тоологдсон байна. Үүний 70.6 хувь болох 6.5 мянган өрх нь жилийн 4 улиралд малаа маллаж, ашиг шимийг авч, амжиргааны эх үүсвэр болгож буй малчин өрх байгаа бол 29.4 хувь буюу 2.7 мянган өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй малтай өрх байна.

2013 оны мал тооллогын дүнгээр 13.7 мянган малчид мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа бөгөөд насны бүлгээр авч үзвэл 43.4 хувь нь 16-34 насны, 50.4 хувь нь 35-аас дээш тэтгэвэрт гарах хүртлэх насныхан, 6.3 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

### ХҮСНЭГТ 2.1. ӨРХ, МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮТЭЦ

| | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|---|---|---|
| 1.Малтай өрх | 8 933 | 9 075 | 9 126 | 9 130 | 9 209 | 9 162 |
| 2.Малчин өрх | 6 746 | 7 057 | 6 909 | 6 834 | 6 530 | 6 466 |
| 3.Малчдын тоо | 15 737 | 15 973 | 15 142 | 14 921 | 13 988 | 13 742 |
| үүнээс: -16-34 насны | 8 245 | 8 301 | 7 293 | 7 061 | 6 459 | 5 960 |
| -эмэгтэй 35-55, эрэгтэй 35-60 насны | 6 217 | 6 292 | 6 557 | 6 601 | 6 658 | 6 920 |
| -Тэтгэврийн насны | 1 275 | 1 380 | 1 292 | 1 259 | 871 | 862 |
| 4.Нийт малчдаас эмэгтэй | 6 917 | 7 148 | 6 725 | 6 825 | 6 399 | 6 285 |
| 5.Насны бүтэц % | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| үүнээс: -16-34 насны | 52.4 | 52.0 | 48.2 | 47.3 | 46.2 | 43.4 |
| -эмэгтэй 35-55, эрэгтэй 35-60 насны | 39.5 | 39.4 | 43.3 | 44.2 | 47.6 | 50.4 |
| -Тэтгэврийн насны | 8.1 | 8.6 | 8.5 | 8.4 | 6.2 | 6.3 |

Тайлбар: - малчдын тоог 15 ба түүнээс дээш насны ангиллаар гаргадаг арга зүйд шилжүүлсэн дүн юм

Энэ оны малтай өрхийн тоог урьд онтой харьцуулахад 0.5 хувь буюу 47 өрхөөр, малчин өрх нь 1.0 хувь буюу 304 өрхөөр тус тус буурсан байна. Харин 2008 онтой харьцуулахад малтай өрх нь 229 өрхөөр өссөн боловч малчин өрхийн хувьд 280 өрхөөр буурчээ.

Сүүлийн 6 жилийн үзүүлэлтээс харахад 2009 оноос хойш малчдын тоо болон малчин өрхийн тоо буурах хандлага ажиглагдаж байна. Малчдын тоог насны ангилаар авч үзвэл 2008 оноос хойш 35-аас дээш тэтгэвэрт гарах хүртлэх насны малчдын тоо өсчээ.

ЗУРАГ 2.1. МАЛЧДЫН ТОО, мян.хүн




## 2.2. МАЛЧДЫН СОЁЛ, АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2013 оны мал тооллогоор нийт малчин өрхийн 92.8 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 78.6 хувь нь телевизортой, 40.3 хувь нь автомашинтай, 0.9 хувь нь трактортой, 50.1 хувь нь мотоцикльтэй гэсэн дүн гарлаа.

Урьд оноос цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо 971 буюу 19.3 хувиар, телевизортой өрхийн тоо 719 буюу 16.5 хувиар, автомашинтай өрхийн тоо 284 буюу 12.2 хувиар, трактортой өрхийн тоо 1 буюу 1.8 хувиар, мотоцикльтэй өрхийн тоо 44 буюу 1.4 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 2.2.1. МАЛЧИН ӨРХИЙН НИЙГЭМ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| | Өрхийн тоо | | | | | | Малчин өрхийн тоонд эзлэх хувь | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2008 | 2011 | 2012 | 2013 |
| Цахилгаан үүсгүүртэй | 5 287 | 5 306 | 5 370 | 6 084 | 5 028 | 5 999 | 78.4 | 89.0 | 77.0 | 92.8 |
| Телевизортой | 4 803 | 4 361 | 4 418 | 5 493 | 4 361 | 5 080 | 71.2 | 80.4 | 66.8 | 78.6 |
| Авто машинтай | 1 428 | 1 698 | 1 701 | 1 997 | 2 321 | 2 605 | 21.2 | 29.2 | 35.5 | 40.3 |
| Трактортой | 53 | 42 | 36 | 37 | 56 | 57 | 0.8 | 0.5 | 0.9 | 0.9 |
| Мотоцикльтэй | 2 270 | 2 793 | 2 694 | 3 374 | 3 198 | 3 242 | 32.8 | 49.4 | 49.0 | 50.1 |

## ЗУРАГ 2.2. МАЛЧИН ӨРХИЙН НИЙГЭМ, АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, мян.өрх




Малчин өрхийн 92.8 хувь нь цахилгаан үүсгүүртэй байгааг төрлөөр задлавал: нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 95.2 хувь нь нарны, 4.8 хувь нь салхины, 2.5 хувь нь бусад (бага оврын мотор, акуммулятор гэх мэт) төрлийн цахилгаан эх үүсгүүртэй байна.

## ХҮСНЭГТ 2.2.2. ЦАХИЛГААН ҮҮСГҮҮРТЭЙ ӨРХИЙН ТОО

| Он | Бүгд | Үүнээс: | | | Дунд эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нарны | Салхины | Бусад | Нарны | Салхины | Бусад |
| 2008 | 5 287 | 4 238 | 548 | 501 | 80.2 | 10.4 | 9.5 |
| 2009 | 5 306 | 4 445 | 604 | 257 | 83.8 | 11.4 | 4.8 |
| 2010 | 5 370 | 4 507 | 579 | 284 | 83.9 | 10.8 | 5.3 |
| 2011 | 6 084 | 5 391 | 520 | 173 | 88.6 | 8.5 | 2.8 |
| 2012 | 5 028 | 4 708 | 287 | 33 | 93.6 | 5.7 | 0.7 |
| 2013 | 5 999 | 5 573 | 282 | 144 | 92.9 | 4.7 | 2.4 |

# ГУРАВДУГААР БҮЛЭГ

## МАЛЫН ТОО, БҮТЭЦ

## 3.1. МАЛЫН ТООНЫ ӨСӨЛТ, БУУРАЛТ

2013 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 2491.4 мянган толгойд хүрч, 2012 оноос 210.8 мянган толгой малаар, 2008 оноос 948.9 мянган толгой малаар тус тус өссөн үзүүлэлтэй байна.

Таван төрлөөрөө авч үзвэл тэмээ 8.9 мянга, адуу 203.1 мянга, үхэр 172.0 мянга, хонь 1216.6 мянга, ямаа 890.8 мянган толгойд тус тус хүрч, 2012 оныхоос тэмээ 849 толгойгоор буурсан хэдий ч адуу 19.5 мянга, үхэр 20.9 мянга, хонь 125.8 мянга, ямаа 45.5 мянган толгойгоор тус тус өссөн байна. Харин таван төрлөөр 2008, 2012, 2013 онуудыг харьцуулж үзвэл тэмээнээс бусад 4 төрөл дээрээ өсчөө

### ХҮСНЭГТ 3.1.1. МАЛЫН ТОО, төрлөөр

| | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2013/2012 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хувь | Зөрүү |
| Бүгд | 1 542 501 | 1 789 735 | 1 979 791 | 2 081 404 | 2 280 581 | 2 491 423 | 109.2 | 210 842 |
| Тэмээ | 9 622 | 10 144 | 10 867 | 10 678 | 9 752 | 8 903 | 91.3 | - 849 |
| Адуу | 118 780 | 131 508 | 148 089 | 164 866 | 183 569 | 203 050 | 110.6 | 19 481 |
| Үхэр | 97 760 | 110 125 | 127 960 | 136 654 | 151 132 | 172 033 | 113.8 | 20 901 |
| Хонь | 733 124 | 853 670 | 961 223 | 991 975 | 1 090 831 | 1 216 623 | 111.5 | 125 792 |
| Ямаа | 583 215 | 684 288 | 731 652 | 777 231 | 845 297 | 890 814 | 105.4 | 45 517 |
| Бодод шилжүүлсэнээр / мян.тол / | 426.1 | 484.7 | 544.0 | 580.0 | 636.8 | 702.6 | 110.3 | 66 |

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг авч үзвэл тэмээ 0.4, адуу 8.2, үхэр 6.9, хонь 48.8, ямаа 35.7 хувийг тус тус эзэлж байна. 2012 онтой харьцуулахад нийт мал сүрэгт адуун сүргийн эзлэх хувийн жин 0.1 пункт, үхэр сүргийн эзлэх хувийн жин 0.3 пункт, хонин сүргийн эзлэх хувийн жин 1 пункт тус тус өсч, ямаан сүргийн эзлэх хувийн жин 1.4 пунктээр буурлаа. Тэмээ сүргийн эзлэх хувийн жин өмнө онтой адил түвшинд байна.

### ХҮСНЭГТ 3.1.2. НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

| Он | Бүгд | Тэмээ | Адуу | Үхэр | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|---|
| 2008 | 100.0 | 0.6 | 7.7 | 6.3 | 47.5 | 37.8 |
| 2009 | 100.0 | 0.6 | 7.3 | 6.2 | 47.7 | 38.2 |
| 2010 | 100.0 | 0.5 | 7.5 | 6.5 | 48.5 | 37.0 |
| 2011 | 100.0 | 0.5 | 7.9 | 6.6 | 47.7 | 37.3 |
| 2012 | 100.0 | 0.4 | 8.1 | 6.6 | 47.8 | 37.1 |
| 2013 | 100.0 | 0.4 | 8.2 | 6.9 | 48.8 | 35.7 |

2012 оны байдлаар авч үзвэл бог малын 56.3 хувийг хонь, 43.7 хувийг ямаа эзэлж байгаа бол 2013 онд бог малын 57.7 хувийг хонь, 42.3 хувийг ямаа эзэлж байна. Сүргийн бүтцийн хувьд бог малын 75.0 орчим хувийг хонь, 25.0 орчим хувийг ямаан

сүрэг эзлэх нь бэлчээрийн зохистой харьцаа болж байдаг. Харин бог малд хонин сүргийн эзлэх хувь урьд оноос 1.4 пунктээр, 2008 оноос 2 пунктээр тус тус өсчээ. Гэсэн ч сүргийн бүтэц болон бэлчээрийн зохистой харьцаа алдагдсан хэвээр байна.

## ЗУРАГ 3.1.1. НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ




Мал тооллогын 2013 оны дүнгээр Сүхбаатар сум 5 төрөл дээр, бусад сумд 2-4 төрөл дээрээ малаа өсгөсөн байна.

Аймагтаа 2013 оны мал тооллогын дүнгээрээ нийт мал болон үхэр, хонь, ямаагаар Баяндэлгэр сум, тэмээгээр Сүхбаатар сум, адуугаар Эрдэнэцагаан сум тус тус тэргүүлж байна.

## ЗУРАГ 3.1.2. МАЛЫН ТОО, сумаар, мян.тол




Улсын хэмжээнд 21 аймгийн дотор бүх малаараа 9-рт, тэмээгээрээ 9-рт, адуугаараа 5-рт, үхрээрээ 6-рт, хониороо 8-рт, ямаагаараа 13-рт тус тус орж байна.

ЗУРАГ 3.1.3. МАЛЫН ТОО, аймгаар, мян.тол




## 3.2. ХУВИЙН /АМИНЫ/ МАЛЫН ТОО

Хувийн малын тоо 2013 онд 2468.2 мянга болж, нийт малын 99.1 хувийг эзэлж байна. Үүний дотор тэмээний 98.2 хувь, адууны 99.2 хувь, үхрийн 99.4 хувь, хонины 98.9 хувь, ямааны 99.3 хувь нь хувийн аж ахуйд байна. Хувийн мал 2012 оноос 212.8 мянга буюу 9.4 хувиар өсч, нийт малд хувийн малын эзлэх хувь өссөөр байна.

## ХҮСНЭГТ 3.2.1. ХУВИЙН МАЛЫН ТОО

| Төрөл | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 1 518 460 | 1 765 692 | 1 957 951 | 2 054 642 | 2 255 407 | 2 468 200 |
| Тэмээ | 9 555 | 10 078 | 10 837 | 10 581 | 9 692 | 8 832 |
| Адуу | 116 958 | 130 027 | 146 528 | 163 238 | 181 998 | 201 414 |
| Үхэр | 96 542 | 109 055 | 126 950 | 135 484 | 150 146 | 170 941 |
| Хонь | 719 315 | 839 531 | 948 109 | 976 235 | 1 075 489 | 1 202 738 |
| Ямаа | 576 090 | 677 001 | 725 527 | 769 104 | 838 082 | 884 275 |

2013 оны байдлаар хувийн нийт малын 48.7 хувийг хонь, 35.8 хувийг ямаа, 8.2 хувийг адуу, 6.9 хувийг үхэр, 0.4 хувийг тэмээ эзэлж байна. 2008 онтой харьцуулах хувийн малын тоо 62.5 хувиар өсчээ. Харин 5-н төрлөөр нь авч үзвэл тэмээнээс бусад төрөл дээрээ өссөн байна.

Мал бүхий 9.2 мянган өрхийг малын тоогоор нь бүлэглэн авч үзвэл 2013 онд 100 хүртэл толгой малтай өрхийн тоо 3404 болж, 2012 оныхоос 269 өрхөөр буурсан боловч 100-гаас дээш малтай өрхийн тоо 6027 болж, 2012 оныхоос 222 өрх буюу 3.8 хувиар өслөө.

2013 оны байдлаар малтай өрхийн 55.2 хувь нь 200 хүртэл толгой малтай байна. Энэ үзүүлэлт нь 2012 оныхоос 3.4 пункт, 2011 оныхоос 4.2 пункт, 2010 оныхоос 8.8 пункт, 2009 оныхоос 13.8 пункт, 2008 оныхоос 16.7 пунктээр тус тус буурчээ.

## ХҮСНЭГТ 3.2.2. МАЛТАЙ ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ

| Бүлэг | Малтай өрхийн тоо | | | | Дунд эрлэх хувь | | | | Малын тоо | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2008 | 2011 | 2012 | 2013 | 2008 | 2011 | 2012 | 2013 | 2008 | 2011 | 2012 | 2013 |
| Дүн | 8 933 | 9 130 | 9 209 | 9 162 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 1 518 460 | 2 054 642 | 2 255 407 | 2 468 200 |
| <10 | 650 | 536 | 533 | 473 | 7.3 | 5.9 | 5.8 | 5.2 | 3 583 | 2 962 | 2 977 | 2 787 |
| 11-30 | 1 095 | 887 | 835 | 782 | 12.3 | 9.7 | 9.1 | 8.5 | 22 271 | 18 311 | 17 158 | 16 015 |
| 31-50 | 892 | 707 | 673 | 637 | 10.0 | 7.7 | 7.3 | 7.0 | 35 683 | 28 677 | 26 940 | 25 620 |
| 51-100 | 1 698 | 1 492 | 1 363 | 1 243 | 19.0 | 16.3 | 14.8 | 13.6 | 124 065 | 111 005 | 101 398 | 92 404 |
| 101-200 | 2 088 | 2 023 | 1 991 | 1 920 | 23.4 | 22.2 | 21.6 | 21.0 | 296 271 | 297 986 | 293 481 | 282 519 |
| 201-500 | 1 906 | 2 437 | 2 596 | 2 677 | 21.3 | 26.7 | 28.2 | 29.2 | 586 472 | 763 544 | 820 861 | 860 362 |
| 501-999 | 485 | 822 | 934 | 1 048 | 5.4 | 9.0 | 10.1 | 11.4 | 308 200 | 548 819 | 632 696 | 704 967 |
| 1000-1499 | 107 | 192 | 238 | 324 | 1.2 | 2.1 | 2.6 | 3.5 | 119 348 | 220 196 | 272 980 | 372 898 |
| 1500-2000 | 7 | 21 | 34 | 40 | 0.1 | 0.2 | 0.4 | 0.4 | 11 628 | 34 042 | 57 078 | 66 789 |
| 2001+ | 5 | 13 | 12 | 18 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.2 | 10 939 | 29 100 | 29 838 | 43 839 |

2013 онд 1000 ба түүнээс дээш малтай 382 өрх тоологдсон нь 2012 оныхоос 98 өрхөөр, 2008 оныхоос 263 өрхөөр тус тус өссөн байна.

### ХҮСНЭГТ 3.2.3. МАЛТАЙ НЭГ ӨРХӨД НООГДОХ МАЛЫН ТОО, бүлэглэлтээр

| Бүлэг | 1 өрхөд ноогдох мал | | | | Үүнээс: | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2008 | 2011 | 2012 | 2013 | Тэмээ | Адуу | Үхэр | Хонь | Ямаа |
| Дүн | 170 | 225 | 245 | 269 | 1 | 22 | 19 | 131 | 97 |
| <10 | 5 | 6 | 6 | 6 | 0 | 1 | 3 | 1 | 1 |
| 11-30 | 20 | 21 | 21 | 20 | 0 | 4 | 4 | 4 | 8 |
| 31-50 | 40 | 41 | 40 | 38 | 0 | 6 | 6 | 10 | 19 |
| 51-100 | 73 | 74 | 74 | 74 | 0 | 9 | 8 | 23 | 34 |
| 101-200 | 142 | 147 | 147 | 147 | 0 | 14 | 12 | 56 | 64 |
| 201-500 | 308 | 313 | 316 | 321 | 1 | 25 | 22 | 150 | 123 |
| 501-999 | 635 | 668 | 677 | 673 | 2 | 46 | 41 | 361 | 222 |
| 1000-1499 | 1 115 | 1 147 | 1 147 | 1 151 | 6 | 90 | 70 | 655 | 330 |
| 1500-2000 | 1 661 | 1 621 | 1 679 | 1 670 | 9 | 162 | 98 | 952 | 447 |
| 2001+ | 2 188 | 2 238 | 2 487 | 2 436 | 10 | 246 | 114 | 1 380 | 685 |

Аймгийн дундажаар хувийн малтай нэг өрхөд 269 толгой мал ногдож байгаа нь 2012 оноос 24 толгой малаар өслөө. Малтай нэг өрхөд тэмээ 1, адуу 22, үхэр 19, хонь 131, ямаа 97 ногдож байна. 1 өрхөд ногдох малын бүтцийг авч үзэхэд 84.8 хувь нь бог мал, 15.2 хувь нь бод мал байна. Сүүлийн 6-н жилийн хугацаанд нэг өрхөд ноогдох малын тоо өсөх хандлага ажиглагдаж байна

## 3.3. ХЭЭЛТЭГЧ МАЛ

Хээлтэгч мал 2013 оны эцэст 1089.1 мянган толгой тоологдсон нь 2012 оныхоос 95.0 мянган толгой буюу 9.6 хувиар өссөн байна.

Төрлөөр нь авч үзбэл ингэ 0.1 мянга толгойгоор буурч бусад 4 төрөл дээрээ өссөн бөгөөд гүү 6.6 мянга, үнээ 7.1 мянга, эм хонь 59.5 мянга, эм ямаа 21.9 мянгаар тус тус өссөн байна.

### ХҮСНЭГТ 3.3. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

| Төрөл | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2013/2012 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хувь | Зөрүү |
| Бүгд | 683 873 | 774 111 | 858 681 | 903 554 | 994 105 | 1 089 143 | 109.6 | 95 038 |
| Ингэ | 3 204 | 3 563 | 3 798 | 3 718 | 3 522 | 3 389 | 96.2 | - 133 |
| Гүү | 36 561 | 39 326 | 43 243 | 48 029 | 53 775 | 60 439 | 112.4 | 6 664 |
| Үнээ | 39 687 | 43 817 | 48 751 | 53 159 | 58 983 | 66 069 | 112.0 | 7 086 |
| Эм хонь | 341 113 | 389 914 | 438 648 | 454 780 | 500 462 | 559 973 | 111.9 | 59 511 |
| Эм ямаа | 263 308 | 297 491 | 324 241 | 343 868 | 377 363 | 399 273 | 105.8 | 21 910 |

Хээлтэгч мал нийт малын 43.7 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 38.1 хувь, адуун сүргийн 29.8 хувь, үхэр сүргийн 38.4 хувь, хонин сүргийн 46.0 хувь, ямаан сүргийн 44.8 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 3.3. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, мян.тол




## 3.4. ТӨЛ БОЙЖИЛТ

2013 онд оны эхний хээлтэгч малын 86.3 хувь буюу 857.6 мянган эх мал төллөж, гарсан төлийн 98.4 хувь буюу 853.3 мянган төл бойжууллаа. Бойжсон төлийн тоо 2012 оныхоос 67.2 мянган толгойгоор өсч, бойжилтын хувь 0.5 пунктээр буурчээ.

Гарсан төлөөс бойжилтын хувийг 5 төрлөөр авч үзвэл ботгоны 97.6 хувь, унаганы 98.7 хувь, тугалын 99.2 хувь, хурганы 98.7 хувь, ишигний 97.8 хувийг тус тус бойжуулаад байна.

ХҮСНЭГТ 3.4.1. ТӨЛ БОЙЖИЛТ

| | Бүгд | | | | Үүнээс: | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2008 | 2011 | 2012 | 2013 | Ботго | Унага | Тугал | Хурга | Ишиг |
| Гарсан төл | 586 153 | 757 391 | 795 225 | 867 458 | 1 517 | 41 061 | 48 031 | 448 175 | 328 674 |
| Бойжсон төл | 438 351 | 744 656 | 786 098 | 853 262 | 1 480 | 40 464 | 47 668 | 442 161 | 321 489 |
| Бойжилтын хувь | 74.8 | 98.3 | 98.9 | 98.4 | 97.6 | 98.5 | 99.2 | 98.7 | 97.8 |

2013 онд бойжуулсан төлийн тоог сумдаар авч үзвэл Онгоноос бусад сумд 0.2-20.0 мянган толгойгоор өссөн байна.

ЗУРАГ 3.4.1. БОЙЖУУЛСАН ТӨЛИЙН ТОО, мян.тол




Аймгийн дунджаар 2013 онд 100 эхээс 78 төл бойжуулсан нь 2012 оноос 9-н төлөөр буюу 10.3 хувиар буураад байна.

Сумдын 100 эхээс бойжуулсан төлийг урьд онтой харьцуулвал: Уулбаян, Түвшинширээ, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Халзан, Асгат сумд 1-10 толгойгоор нэмэгдэж, Дарьганга, Наран, Баруун-Урт, Мөнххаан, Түмэнцогт сумд 2-8 толгойгоор бууруулсан байна. Харин Баяндэлгэр, Онгон сумд хэвийн түвшинд байна.

ХҮСНЭГТ 3.4.2. 100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ

| | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 61 | 87 | 85 | 87 | 87 | 78 |
| Ботго | 37 | 46 | 48 | 44 | 47 | 44 |
| Унага | 35 | 77 | 76 | 80 | 82 | 67 |
| Тугал | 56 | 87 | 88 | 84 | 86 | 72 |
| Хурга | 66 | 87 | 86 | 88 | 89 | 79 |
| Ишиг | 60 | 88 | 84 | 87 | 86 | 81 |

ЗУРАГ 3.4.2. 100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ




## 3.5. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

2013 онд оны эхний нийт малын 1.1 хувь болох 26.0 мянган толгой мал хорогдсон нь өнгөрсөн оныхоос 5.1 мянган толгой малаар өсчээ. Нийт хорогдсон

малын 46.9 хувийг ямаа, 42.6 хувийг хонь, 6.3 хувийг үхэр, 3.8 хувийг адуу, 0.4 хувийг тэмээ эзэлж байна.

### ХҮСНЭГТ 3.5.1. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

| Төрөл | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | Оны эхний малд эзлэх хувь | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
| Бүгд | 387 874 | 22 731 | 60 930 | 54 654 | 20 915 | 25 971 | 22.7 | 1.5 | 3.4 | 2.8 | 1.0 | 1.1 |
| Тэмээ | 1 130 | 114 | 129 | 124 | 85 | 99 | 10.4 | 1.2 | 1.3 | 1.1 | 0.8 | 1.0 |
| Адуу | 39 486 | 1 574 | 1 818 | 1 731 | 753 | 977 | 23.8 | 1.3 | 1.4 | 1.2 | 0.5 | 0.5 |
| Үхэр | 33 097 | 2 191 | 6 722 | 4 214 | 1 140 | 1 641 | 26.6 | 2.2 | 6.1 | 3.3 | 0.8 | 1.1 |
| Хонь | 157 857 | 10 259 | 26 978 | 23 022 | 8 847 | 11 066 | 20.3 | 1.4 | 3.2 | 2.4 | 0.9 | 1.0 |
| Ямаа | 156 304 | 8 593 | 25 283 | 25 563 | 10 090 | 12 188 | 24.7 | 1.5 | 3.7 | 3.5 | 1.3 | 1.4 |

Том малын зүй бус хорогдолыг урьд онтой харьцуулахад Асгат, Дарьганга, Сүхбаатар, Халзан, Эрдэнэцагаан, Түмэнцогт, Баруун-Урт сумдын хорогдол 0.03 – 5.0 мянган толгой малаар өсчээ.

Сүүлийн 11-н жилийн хугацааны том малын зүй бусын хорогдолыг харахад 2008 онд 387.9 мянган толгой мал хорогдсон нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

### ЗУРАГ 3.5. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, мян.тол




Нийт хорогдлоос 26.2 хувь буюу 6.8 мянган толгой мал гэнэтийн аюулаар, 4.6 хувь нь өвчнөөр хорогдсон байна. Энэ нь урьд оноос 3.9 мянган толгойгоор дээгүүр гүйцэтгэлтэй байна.

### ХҮСНЭГТ 3.5.2. ГЭНЭТИЙН АЮУЛААР ХОРОГДСОН МАЛЫН ТОО

| Төрөл | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 243 503 | 747 | 7 947 | 6 062 | 2 218 | 6 797 |
| Тэмээ | 744 | 1 | 14 | 1 | 8 | 21 |
| Адуу | 25 755 | 29 | 302 | 16 | 47 | 186 |
| Үхэр | 20 487 | 55 | 391 | 339 | 91 | 354 |
| Хонь | 100 308 | 379 | 3 899 | 3 024 | 1 126 | 3 177 |
| Ямаа | 96 209 | 283 | 3 341 | 2 682 | 946 | 3 059 |

## 3.6. МАЛЫН ХЭЭЛ ХАЯЛТ, СУВАЙРАЛТ

2013 онд оны эхний хээлтэгч малын 8.2 хувь болох 89.3 мянган мал хээл хаяж, сувайрсны улмаас төл өгөөгүй байна.

Хээл хаяж, сувайрсан хээлтэгч малын тоо урд оныхоос 32.7 хувь буюу 22.1 мянган толгой малаар өсчээ.

Төл өгөөгүй хээлтэгч малын 83.9 хувь буюу 74.9 мянган толгой мал нь сувайрсан, 16.1 хувь буюу 14.3 мянган толгой мал нь хээл хаясан эх мал байна.

### ХҮСНЭГТ 3.6. ХЭЭЛ ХАЯЖ, СУВАЙРСАН МАЛЫН ТОО

| Төрөл | Сувайрсан | | | | | | Хээл хаясан | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
| Бүгд | 41 161 | 47 545 | 41 026 | 47 578 | 54 286 | 74 947 | 20 889 | 12 550 | 13 019 | 13 688 | 12 961 | 14 335 |
| Ингэ | 198 | 164 | 117 | 178 | 165 | 137 | 41 | 35 | 15 | 19 | 15 | 24 |
| Гүү | 6 210 | 4 637 | 5 038 | 5 445 | 5 757 | 9 213 | 2 354 | 798 | 1 005 | 1 044 | 799 | 1 209 |
| Үнээ | 4 369 | 3 351 | 3 345 | 4 328 | 5 195 | 9 512 | 1 663 | 672 | 749 | 989 | 793 | 911 |
| Эм хонь | 15 921 | 21 015 | 17 385 | 19 969 | 22 457 | 31 316 | 7 639 | 6 049 | 5 830 | 5 963 | 5 452 | 5 436 |
| Эм ямаа | 14 463 | 18 378 | 15 141 | 17 658 | 20 712 | 24 769 | 9 192 | 4 996 | 5 420 | 5 673 | 5 902 | 6 755 |

## 3.7. ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО:

2013 онд 23.7 мянган хээлтүүлэгч мал тоологдож, 2012 оныхоос 1.5 мянган толгойгоор буюу 6.8 хувиар өссөн байна.

### ХҮСНЭГТ 3.7.1. ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО

| Төрөл | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 15 434 | 17 326 | 19 192 | 21 136 | 22 166 | 23 667 |
| Буур | 99 | 119 | 147 | 138 | 149 | 118 |
| Азарга | 6 126 | 6 359 | 6 866 | 7 514 | 7 926 | 8 653 |
| Бух | 1 097 | 1 257 | 1 471 | 1 573 | 1 671 | 1 798 |
| Хуц | 4 706 | 5 657 | 6 436 | 7 116 | 7 236 | 7 905 |
| Ухна | 3 406 | 3 934 | 4 272 | 4 795 | 5 184 | 5 193 |

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь тэмээ, адууны хувьд үржлийн нормоороо, харин үхэр, хонь, ямаа зэргийн үржлийн норм алдагдсаар байна.

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 50 хээлтэгч ногдох ёстой атал 2013 онд аймгийн дунджаар 71 эм хонь, 77 эм ямаа ногдож байгаа нь 42-54 хувиар өндөр үзүүлэлтэй байна.

### ХҮСНЭГТ 3.7.2. ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО

| Төрөл | Үржлийн норм | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Буур | 20 | 32 | 30 | 26 | 27 | 24 | 29 |
| Азарга | 10 | 6 | 6 | 6 | 6 | 7 | 7 |
| Бух | 25 | 36 | 35 | 33 | 34 | 35 | 37 |
| Хуц | 50 | 72 | 69 | 68 | 64 | 69 | 71 |
| Ухна | 50 | 77 | 76 | 76 | 72 | 73 | 77 |

## 3.8. МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

2013 онд оны эхний малын 24.1 хувьтай тэнцэх 550.6 мян.толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага 2012 оныхоос 15.4 мянган толгойгоор буурсан байна.

Малтай нэг өрх дунджаар 60 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан нь өмнөх онтой харьцуулвал 1 толгой малаар буурсан байна.

### ХҮСНЭГТ 3.8.1. МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

| Төрөл | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | Оны эхний малд эзлэх хувь | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
| Бүгд | 217 169 | 324 100 | 405 184 | 588 389 | 566 006 | 550 647 | 12.7 | 21.0 | 22.6 | 29.7 | 27.2 | 24.1 |
| Тэмээ | 1 325 | 851 | 859 | 1 736 | 2 593 | 2 096 | 12.2 | 8.8 | 8.5 | 16.0 | 24.3 | 21.5 |
| Адуу | 24 505 | 13 856 | 11 536 | 15 955 | 19 861 | 25 572 | 14.8 | 14.2 | 8.8 | 10.8 | 12.0 | 13.9 |
| Үхэр | 20 303 | 20 080 | 13 834 | 27 807 | 30 283 | 31 945 | 16.3 | 20.5 | 12.6 | 21.7 | 22.2 | 21.1 |
| Хонь | 114 583 | 167 449 | 200 555 | 332 372 | 294 956 | 274 760 | 14.8 | 22.8 | 23.5 | 34.6 | 29.7 | 25.2 |
| Ямаа | 56 453 | 121 864 | 178 400 | 210 519 | 218 313 | 216 274 | 8.9 | 20.9 | 26.1 | 28.8 | 28.1 | 25.6 |

Оны эхний бүх малын 22.1 хувь, тэмээний 23.5 хувь, адууны 12.6 хувь, үхрийн 18.6 хувь, хонины 22.6 хувь, ямааны 24.3 хувийг тус тус хэрэглээнд зарцуулжээ.

Хэрэглээнд зарцуулсан малын 89.2 хувийг бог мал, 10.8 хувийг бод мал эзлэж байна.

### ХҮСНЭГТ 3.8.2. ЗАХ ЗЭЭЛД ХУДАЛДАН БОРЛУУЛСАН БОЛОН АЖ АХУЙН ДОТООДОД ХЭРЭГЛЭСЭН МАЛЫН ТОО

| Төрөл | Зах зээлд худалдан борлуулсан | | | | | Аж ахуйн дотоодод хэрэглэсэн | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2008 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2008 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
| Бүгд | 126.6 | 198.1 | 284.2 | 287.1 | 330.3 | 92.9 | 94.6 | 105.6 | 106.2 | 112.2 |
| Тэмээ | 0.8 | 0.6 | 1.1 | 1.3 | 1.5 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.0 | 0.1 |
| Адуу | 9.0 | 8.9 | 10.9 | 12.0 | 13.9 | 7.6 | 5.4 | 5.7 | 6.0 | 5.5 |
| Үхэр | 9.7 | 9.5 | 15.8 | 17.3 | 18.4 | 8.3 | 6.6 | 7.7 | 8.3 | 7.8 |
| Хонь | 66.0 | 99.7 | 156.3 | 149.5 | 167.0 | 43.8 | 42.8 | 51.5 | 49.6 | 53.7 |
| Ямаа | 41.1 | 79.4 | 100.1 | 107.0 | 129.5 | 33.1 | 39.7 | 40.6 | 42.3 | 45.2 |

Хэрэглээнд зарцуулсан малын 60.0 хувийг зах зээлд худалдан борлуулж, 20.4 хувийг аж ахуйн дотоод хэрэгцээнд зарцуулсан байна.

Малтай нэг өрх дунджаар 36 толгой малыг зах зээлд борлуулж, 12 толгой малыг өрхийн хэрэглээндээ зарцуулсан байна.

## 3.9. СҮРГИЙН БҮТЭЦ

Нийт сүргийн бүтцийг 2013 оны байдлаар авч үзэхэд 35.9 хувь буюу 893.6 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 19.5 хувь буюу 485.0 мянган толгой нь ажлын

ба бэлтгэлийн насны эр мал, 43.7 хувь буюу 1089.1 мянган толгой нь хээлтэгч мал, 0.9 хувь буюу 23.7 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна.

### ХҮСНЭГТ 3.9. СҮРГИЙН БҮТЭЦ

| | мян.тол | | | | Хувиар | | | | 2013/2012 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2008 | 2011 | 2012 | 2013 | 2008 | 2011 | 2012 | 2013 | Хувь | Зөрүү |
| **Бүгд** | **1 542.5** | **2 081.4** | **2 280.6** | **2 491.4** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **109.2** | **210.8** |
| Төл, өсвөр насны мал | 485.7 | 744.5 | 824.9 | 893.6 | 31.5 | 35.8 | 36.2 | 35.9 | 108.3 | 68.7 |
| Ажлын ба бэлтгэлийн насны эр | 357.5 | 412.2 | 439.4 | 485.0 | 23.2 | 19.8 | 19.3 | 19.5 | 110.4 | 45.6 |
| Хээлтэгч | 683.9 | 903.6 | 994.1 | 1 089.1 | 44.3 | 43.4 | 43.6 | 43.7 | 109.6 | 95.0 |
| Хээлтүүлэгч | 15.4 | 21.1 | 22.2 | 23.7 | 1.0 | 1.0 | 1.0 | 0.9 | 106.9 | 1.5 |

